



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар

1/111

Улаанбаатар хот

Захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 32 дугаар зүйлийн 32.1.2, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4, 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах 2028 арга хэмжээ батлах тухай” 18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус дүүргийн Онцгой байдлын хэлтсийн даргын саналыг үндэслэн Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн гишүүн Т.Бямбахишигийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг”-ийн гишүүний үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг”-ийн гишүүнээс чөлөөлөгдсөн гишүүний орон тоонд Отгонбаярын Билэгсайханыг томилж, хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан тус дүүргийн Засаг даргын 2024 оны “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг шинэчлэн байгуулах тухай” А/01 дүгээр захирамжийн хавсралтын Т.Бямбахишигт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ